



**ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 дугаар сарын 31

Дугаар 02/26

Жаргалант сум

**“Ахмад настны хөгжлийн” хөтөлбөрийн болон
хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгүүдийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Ахмад настны хөгжлийн” хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Засаг дарга (Л.Учрал)-д үүрэг болгосугай.

ДАРГА *Ш.Билгүүнбаатар* Ш.БИЛГҮҮНБААТАР



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны
12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдааны
02/36 тогтоолын нэгдүгээр хавсралт

“АХМАД НАСТНЫ ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨР

Нэг.Ерөнхий мэдээлэл

Дэлхий дахинд ахмад настны насжилт эрчимтэй нэмэгдэж байгаа талаар “Дэлхийн насжилтын хяналтын индекс” 2015 оны судалгааны тайланд дурдсан байна. Одоогийн байдлаар 60-аас дээш насны 900 гаруй сая ахмад настан байгаа нь дэлхийн нийт хүн амын 12.3 хувийг эзэлж байгаа бол 2030 онд 1.4 тэрбум, 2050 онд 2.0 тэрбум болох төлөвтэй байна гэж дүгнэжээ.

Дэлхийн насны хяналтын индексийг ахмад настны аж байдал, эрүүл мэнд, чадамж, орчин нөхцөл гэсэн 4 бүлэг үзүүлэлтээр тооцдог бөгөөд 2015 онд уг индекс тооцсон 96 орноос манай улс 72-т, үүний дотор аж байдлын үзүүлэлтээр 31-д, эрүүл мэндийн үзүүлэлтээр 93-т, чадамжийн үзүүлэлтээр 64-т, орчин нөхцөлийн үзүүлэлтээр 62-т орсон байна.

Монгол улсад 60 ба түүнээс дээш настны нийт хүн амд эзлэх хувь 2015 онд 6.4% байсан бол 2030 онд 11.9%, 2050 онд 21.1%-тай тэнцэх магадлалтай байна гэж судалгаагаар гарсан байна.

Манай сумын хувьд 2023 оны байдлаар 570 гаруй ахмад настан байгаа нь нийт хүн амын 16 хувийг эзэлж байгаа бол тэдгээрээс 60-69 насны 308, 70-89 насны 134, 90-ээс дээш насны 6 ахмад настан байна. Нийт ахмадын 31 орчим хувь нь эрэгтэй ахмад байгаа нь сэтгэл эмзэглүүлсэн асуудал болоод байна.

Дээрх баримтууд нь ахмад настны эрүүл мэндийн талаар шат шатандаа анхааралдаа авах шаардлагатайг харуулж байна.

Монгол улсад ахмад настнуудын боловсролын түвшин харьцангуй өндөр ч хөдөлмөр эрхлэлтийн түвшин доогуур байна.

Сумын нийт ахмадаас 228 буюу 39.9 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Тэдгээрийн 58% нь мал аж ахуйн салбарт, 25% нь газар тариалангийн салбарт, төрийн байгууллагад 0.05% нь , үлдсэн нь үйлчилгээний болон бусад салбарт ажиллаж байна. Хэдийгээр ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжиж байгаа ч хамрагдалт муу, уг хөтөлбөрт жилд 1-2 ахмад хамрагдаж байгаа нь хангалтгүй байгаа юм.

Монгол улс дахь “Хүний эрх, эрх чөлөөний байдал”-ын талаарх илтгэлд нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 53.3% нь тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авдаг, 97% нь бага тэтгэвэртэй амьдарч, амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаагаас ахмадууд тэтгэврийн зээл ихээр авч байна гэж дурджээ.

Иймээс ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар авах арга хэмжээг нэмэгдүүлэхийн тулд төрөл бүрийн сургалтад хамруулж, гэрээр хөдөлмөр эрхлэхэд туслах, өөрийн чадавхад тохирсон ажлын байранд ажиллуулах зэрэг арга хэмжээ авах хэрэгтэй болоод байна.

Ахмад настны талаар зайлшгүй шаардлагатай байгаа эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд тусгай хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж энэхүү хөтөлбөрийг боловсрууллаа.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго

Ахмад настны эрүүл мэндийг хамгаалж, урт наслуулах, аж байдлыг дээшлүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн ядуурлаас хамгаалах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, хуримтлуулсан мэдлэг чадвараа хойч үедээ өвлүүлэн үлдээх, алдаршуулах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авахад хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав.Хөтөлбөрийн зорилт

3.1.Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1.1.Ахмад настны эрүүл мэнд, эрүүл насжилтыг дэмжих,
- 3.1.2.Хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлж, ядуурлаас хамгаалах
- 3.1.3.Амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад туслах
- 3.1.4.Ахмад настны чадамжийг дэмжих, сургах алдаршуулах

Дөрөв.Хэрэгжүүлэх үйл ажиллагаа



4.1.Эрүүл мэнд, эрүүл насжилтыг дэмжих зорилтын хүрээнд:

- 4.1.1.Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах
- 4.1.2.Эрүүл зөв хооллолтын зөвлөгөө, сургалтад хамруулах
- 4.1.3.Хэвтрийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, ганц бие ахмадын судалгааг гарган тэдэнд тусламж дэмжлэг үзүүлэх
- 4.1.4.Ахмадын ордны сургалтын танхимд өдрийн үйлчилгээ явуулах

4.2.Хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлж, ядуурлаас хамгаалах зорилтын хүрээнд:

- 4.2.1.Ахмад настныг насан туршийн боловсролд хамрагдах үйл явцыг дэмжих, чадавхжуулах сургалтад хамруулах замаар шинээр орлогын эх үүсвэр бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- 4.2.2.Аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран “Нэг байгууллага- Нэг ахмад” уриан дор хөдөлмөрийн чадвартай ахмад настныг түр болон байнгын ажлын байраар хангах
- 4.2.3.Ахмадын байгууллага дээр ахмад настанд зөвлөгөө өгөх баг бүрдүүлж төлбөртэй ажиллуулан багийн бүрэлдэхүүний орлогыг нэмэгдүүлэх

4.3.Амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад туслах зорилтын хүрээнд:

- 4.3.1.Орон байрны нөхцөлөө сайжруулахыг хүссэн ахмадуудыг судалж, түрээсийн байранд оруулах асуудлыг шийдвэрлэхэд туслах
- 4.3.2.Байгууллагуудын “Ахмадын сан”-гийн тодорхой хувийг тэтгэвэрт гарч буй ахмад настны орон байрны нөхцөлийг сайжруулахад зарцуулах ажлыг дэмжих талаар санаачилгатай ажиллах

4.4.Ахмад настны чадамжийг дэмжих, сургах алдаршуулах зорилтын хүрээнд:

- 4.4.1.Анхдагч, алдар гавьяатай ахмадуудыг алдаршуулах, тэдгээр ахмадуудаар хүүхэд залууст уламжлалт ёс, заншил, өв уламжлалын талаар зөвлөгөө өгүүлэх
- 4.4.2.Ахмад настныг софть волейбол, граунд гольф, байт харваа зэрэг спортын шинэ төрөлд сургаж, тоног хэрэгслээр ханган улс аймгийн тэмцээн уралдаанд оролцох боломж олгох
- 4.4.3.Ахмадын байгууллагын сургалтын танхимыг шаардлагатай тоног төхөөрөмж авч өгөн сургалт явуулах нөхцөл боломжоор хангах
- 4.4.4.Урлаг соёлын арга хэмжээ явуулахад дэмжлэг үзүүлж, хөгжим зэрэг техник хэрэгсэлтэй болгох
- 4.4.5.Ахмад настныг цахим орчинд ажиллах наад захын мэдлэгтэй болоход тусалж тусгай сургалтад хамруулах
- 4.4.6.Тэргүүн туршлага судлах шугамаар аялал зохион байгуулах
- 4.4.7.Ажил хөдөлмөр, алдар гавьяагаа үнэлүүлж чадаагүй ахмадын судалгааг үндэслэн төрийн одон медальд тодорхойлох, алдаршуулах.

Тав.Хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

- 5.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон нийтийн ил тод байдлыг хангана.
- 5.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн засаг захиргаа, бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын оролцоонд түшиглэнэ.
- 5.3.Хөтөлбөрт ахмадуудыг ялгаваргүй, тэгш эрхтэйгээр хамруулна.

Зургаа.Хөтөлбөр хэрэгжих хугацаа

“Ахмад настны хөгжлийн хөтөлбөр”- ийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

Долоо.Хөтөлбөрийн санхүүжилт, тайлагнал

7.1.Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

- 7.1.1.Орон нутгийн төсвийн болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө

- 7.1.2.Төсвийн болон хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалт
7.1.3.Иргэдээс ахмад настан, ахмадын байгууллагад өгсөн хандив, тусламж
7.1.4.Бусад эх үүсвэр

7.2.Хөтөлбөрийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, тайланг тухайн жилийн эцэст зохих журмын дагуу гаргана.



Найм.Хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүн

- 8.1.Хөтөлбөрт хамрагдсан ахмадуудын амьдралын чанар дээшилнэ.
8.2.Хөтөлбөрт хамрагдсан ахмадуудын эрүүл мэнд хамгаалагдаж, эрүүл хооллолтын талаарх мэдлэгтэй болсноор өвчлөл буурна.
8.3.Боломжтой ахмадууд хөдөлмөр эрхэлж орлого нь нэмэгдсэн байна.
8.4.Хөдөлмөрөө үнэлүүлж, төрийн одон медалиар шагнуулахаас гадна алдар гавьяагаа алдаршуулж, залууст мэдлэг чадвараа өвлүүлнэ.
8.5.Ахмадын нийгмийн амьдралд оролцох оролцоо, идэвх нэмэгдэнэ.

---000---

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны
12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдааны
09.14.6 тогтоолын хоёрдугаар хавсралт

“АХМАД НАСТНЫ ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025-2028 ОНЫ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.12.20.

Жаргалант

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хүрэх түвшин					Төсөв /сая /сая төг/		
			2025 он		2026 он		2027 он		2028 он	
			Хүрэх түвшин	Төсөв /сая төг/	Хүрэх түвшин	Төсөв /сая төг/	Хүрэх түвшин	Төсөв /сая төг/	Хүрэх түвшин	Төсөв /сая төг/
Зорилт 1. Ахмад настны эрүүл мэнд, эрүүл насжилтыг дэмжих										
1	Эрүүл хооллолтын зөвлөгөө, сургалтад хамруулах	Эрүүл мэндийн болон сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулна.	4 удаагийн сургалтанд нийт 100 гаруй ахмад хамруулна.	1.5	4 удаагийн сургалтад нийт 150 гаруй ахмад хамруулна.	2.25	4 удаагийн сургалтад нийт 150 гаруй ахмад хамруулна.	2.25	4 удаагийн сургалтад нийт 200 гаруй ахмад хамруулна.	3.0
Зорилт 2. Хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлж, ядуурлаас хамгаалах										
2	Ахмад настныг насан туршийн боловсролын чадавхжуулах сургалтад хамруулах замаар орлогын шинэ эх үүсвэртэй болгох	НТБ-ын сургалтын жагсаалтаас сонгон авч хамтран сургалт зохион байгуулна.	Жилд 3 удаагийн сургалтанд 10 ахмад, нийт 30 ахмад хамруулна.	0.45	Жилд 3 удаагийн сургалтад 10 ахмад, нийт 30 ахмад хамруулна.	0.45	Жилд 5 удаагийн сургалтад 10 ахмад, нийт 50 ахмад хамруулна.	0.75	Жилд 5 удаагийн сургалтад 1.0 ахмад, нийт 50 ахмад хамруулна.	0.75
3	ААНБ-тай хамтран "Нэг байгууллага-Нэг төрийн болон ААНБ-тай тохиролцсоны	Төрийн болон ААНБ-тай тохиролцсоны	Энэ онд 5 хүртэлх		Энэ онд 5 хүртэлх		Энэ онд 5 хүртэлх		Энэ онд 5 хүртэлх	

	ахмад" уриан дор хөдөлмөрийн чадвартай ахмад настныг түр болон байнгын ажлын байраар хангах	Дагуу ахмад настанг ажлын байраар хангах ажил зохион байгуулна.	ахмадыг ажлын байртай болгоно.	-	ахмадыг ажлын байртай болгоно.	-	ахмадыг ажлын байртай болгоно.	-	ахмадыг ажлын байртай болгоно.
4	Ахмадын байгууллага дээр ахмад настанд зөвлөгөө өгөх баг бүрдүүлж, төлбөртэй ажиллуулан багийн бүрэлдэхүүний орлогыг нэмэгдүүлэх	Мэргэжилтэй ахмадын судалгааг үндэслэн багийн бүрэлдэхүүнийг сонгон ажиллуулна.	Багийн бүрэлдхүүн 5 хүнтэй байх бөгөөд 100 хүртэл ахмадад зөвлөгөө өгүүлнэ.	1.5	Багийн бүрэлдэхүүн 5 хүнтэй байх бөгөөд 100 хүртэл ахмадад зөвлөгөө өгүүлнэ.	2.0	Багийн бүрэлдэхүүн 5 хүнтэй байх бөгөөд 100 хүртэл ахмадад зөвлөгөө өгүүлнэ.	2.0	Багийн бүрэлдэхүүн 5 хүнтэй байх бөгөөд 100 хүртэл ахмадад зөвлөгөө өгүүлнэ.

Зорилт 3. Амьдрах орчин нөхцлийг сайжруулахад туслах

5	Орон байрны нөхцлөө сайжруулахыг хүссэн ахмадуудыг судалж, түрээсийн байраар хангах асуудлыг шийдвэрлэх	Өргөдөл хүсэлтийн дагуу дарааллаар нь хамрагдах ажлыг зохион байгуулна.	Энэ онд 2 хүн орон сууцтай болгоно.	-	Энэ онд 3 хүн орон сууцтай болгоно.	-	Энэ онд 3 хүн орон сууцтай болгоно.	-	Энэ онд 4 хүн орон сууцтай болгоно.
6	Байгууллагуудын "Ахмадын сан"- гийн тодорхой хувийг тэтгэвэрт гарч буй ахмад настны орон байрны нөхцлөө сайжруулахад зарцуулах ажлыг	"Ахмадын сан"- гийн зарцуулах журмын дагуу байгууллага тус бүр дээр журам гаргуулж, энэ ажлыг зохион байгуулна.	"Ахмадын сан"-тай байгууллага тус бүр нэг ахмадад тусламж үзүүлнэ.	-	"Ахмадын сан"-тай байгууллага тус бүр нэг ахмадад тусламж үзүүлнэ.	-	"Ахмадын сан"-тай байгууллага тус бүр нэг ахмадад тусламж үзүүлнэ.	-	"Ахмадын сан"-тай байгууллага тус бүр нэг ахмадад тусламж үзүүлнэ.

Зорилт 4. Ахмад настны чадамжийг дэмжих, сургах, алдаршуулах									
Дэмжих талаар санаачлагатай ажиллах									
7	Анхдагч, алдар гавьяатай ахмадуудыг алдаршуулах, тэднээр хүүхэд залууст өв уламжлал, ёс, заншилны талаар зөвлөгөө өгүүлэх	Зөвлөгөө өгөх мэдлэг, чадвартай гавьяатай ахмадын судалгааг үндэслэн зохион байгуулна.	Алдар гавьяатай 5 ахмадыг алдаршуулж, зөвлөгөө өгүүлнэ.	1.0	Алдар гавьяатай 5 ахмадыг алдаршуулж, зөвлөгөө өгүүлнэ.	1.5	Алдар гавьяатай 5 ахмадыг алдаршуулж, зөвлөгөө өгүүлнэ.	1.5	Алдар гавьяатай 5 ахмадыг алдаршуулж, зөвлөгөө өгүүлнэ.
8	Ахмад настныг софт волейбол, граунд гольф, нумт харваа зэрэг спортын тоног хэрэгсэлтэй болгож, сургаж бэлтгэх	Үүний тулд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах	Софтод 3 баг, гольфод 6 хүн, Нумт харваанд 5 хүн бэлдэж тэмцээнд оролцуулна	Төсөв 3.0 Шата хуун 1.0	Софтод 4 баг, гольфод 12 хүн, Нумт харваанд 10 хүн бэлдэж тэмцээнд оролцуулна.	Шата хуун 2.0	Софтод 4 баг, гольфод 12 хүн, Нумт харваанд 15 хүн бэлдэж тэмцээнд оролцуулна.	Шата ахуун 2.0	Софтод 2 баг, гольфод 12 хүн, Нумт харваанд 20 хүн бэлдэж тэмцээнд оролцуулна.
9	Сумын ахмадуудын дунд жил бүр спортын тэмцээнийг зохион байгуулах	Хөзөр, гар бөмбөг, шатар, даам, теннис, софт волейболын тэмцээн хавар намар 2 удаа зохиох	Цөлөөт цагаа зөв өнгөрүүлэх, хөдөлгөөн хийж эрүүл мэндийг дэмжнэ.	3.0	Цагаа зөв өнгөрүүлж хөдөлгөөн хийж эрүүл мэндийг дэмжинэ.	3.0	Цагаа зөв өнгөрүүлж хөдөлгөөн хийж эрүүл мэндийг дэмжинэ.	3.0	Цөлөөт цагаа зөв өнгөрүүлж хөдөлгөөн хийж эрүүл мэндийг дэмжинэ.
10	Ахмадын сургалтын танхимыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган, сургалт	Дэлгэц ЛЕД том телевиз, сандал ширээ нэмж авна.	Нэг удаа 20-30 хүн, жилд 100 ахмадад сургалт явуулна.	6.0	-	-	-	-	-

